| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 28,090,200.00 | 26,511,645.00 | 1,578,555.00 | 94.38 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 25,601,300.00 | 24,511,645.00 | 1,089,655.00 | 95.74 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,488,900.00 | 2,000,000.00 | 488,900.00 | 80.36 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,919,153,000.00 | 1,919,153,000.00 | - | 100.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,919,153,000.00 | 1,919,153,000.00 | - | 100.00 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 1,919,153,000.00 | 1,919,153,000.00 | - | 100.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 2,000,000.00 | 534,500.00 | 1,465,500.00 | 26.73 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 82.00 | 59.00 | 23.00 | 71.95 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 62.00 | 41.00 | 21.00 | 66.13 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 19.00 | 17.00 | 2.00 | 89.47 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Мал эмнэлгийн газар нь мал эмнэлгийн тасгийн албан хаагч, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нарыг мэргэжил арга зүй, удирдлага зохион байгуулалтаар ханган, мал эмнэлгийн нэгдсэн 5 төрлийн үйлчилгээг малчдад үзүүлж, мал эмнэлгийн үйлчилгээг малчдад үзүүлж, мал эмнэлгийн үйлчилгээг цахимаар харах боломжтой болгон “Иргэн төв төрийн үйлчилгээ”-г нэвтрүүлж ажилласан байна.

Алсын хараагаа хүмүүнд ээлтэй, малчинд ойрхон мал эмнэлэг, дэлхийд тэргүүлэх цэвэр бүтээгдэхүүн гэж тодорхойлсон.

Эрхэм зорилго нь мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах улмаар нийтийн эрүүл мэндийг хамгаалах худалдааны чөлөөт байдлыг дэмжихэд оршино.

Мал эмнэлгийн газар нь тайлант онд 82 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулахаар бүтэц орон тоо батлагдсанаас удирдах албан тушаалтан 1, гүйцэтгэх 41, үйлчилгээний 17 нийт 59 орон тоогоор үйл ажиллагаа явуулж 23 орон тоо дутуу ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Мал эмнэлгийн газар нь мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах замаар мал эмнэлгийн салбарыг оновчтой нэгдсэн бодлогоор хангагч, худалдааны чөлөөт байдлыг дэмжих чиг үүргийг хэрэгжүүлдэг, Мал Эмнэлгийн Ерөнхий Газрын харьяа байгууллага юм.

Мал эмнэлгийн газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хууль
- Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль
- Малын генетик нөөцийн тухай хууль
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтад өөрчлөлт орсон.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мал эмнэлгийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мал эмнэлгийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мал эмнэлгийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,107.4 мянган төгрөгөөр буюу 0.39 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---------------------|--------------------|--------------------|-----------------------------|
| | | | /мянган төгрөгөөр/ 3=2-1 |
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 84,459.6 | 101,508.2 | 17,048.5 |
| Үндсэн хөрөнгө | 979,514.0 | 958,358.1 | (21,156.0) |
| Нийт хөрөнгө | 1,063,973.7 | 1,059,866.2 | (4,107.4) |

| | | | |
|--|--------------------|--------------------|------------------|
| Богино хугацаат өр төлбөр | 105,151.8 | 339.8 | (104,812.0) |
| Хуримтлагдсан үр дүн | 958,821.9 | 1,059,526.5 | 100,704.6 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 1,063,973.7 | 1,059,866.2 | (4,107.4) |

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 17,048.5 мянган төгрөгөөр өссөн нь дээд газраас эм боох материал 1,990,273.9 мянган төгрөг шилжин ирж 1,972,607.3 мянган төгрөг зарцуулж бараа материал дутуу зарцуулсантай холбоотой эм боох материалын дүн өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 21,156 мянган төгрөгөөр буурсан нь 40,342.2 мянган төгрөгийн шилжиж ирсэн хөрөнгө, 508,274.1 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Мал эмнэлгийн газрын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,007,115.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой зардлыг тус тус өсгөж 1,921,153.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Төв аймгийн Мал эмнэлгийн газрын төсвийн төслийг өсгөсөн нь албан хаагчдын цалинд 2023 оны 07 сарын 01-ны өдрөөс цалин нэмэгдсэн, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр өмнөх онд өглөгтэй байсан энэ онд төлөвлөгөө нэмж батлагдсанаар өссөн зэрэг өөрчлөлт орсноос шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 914,037.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,919,153.0 мянган төгрөгийг олгохоор баталсан байна.

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,919,153.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 1,592,945.9 мянган төгрөг буюу 82.9 хувьтай зарцуулж, 327,776.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Энэ нь цалин, байр ашиглалттай холбоотой зардал, бараа материал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|--|-------------|-------------|-----------|---------|
| 1 | 80101 Үндсэн үйл ажиллагаа | 1,766,839.3 | 1,580,650.8 | 186,188.5 | 89.5 |
| 2 | 82504 Малын халдварт өвчнөөс урьдчилан | 49,755.1 | 48,317.9 | 1,437.2 | 97.1 |
| 3 | 82507 Малыг архаг халдварт өвчнөөс | 76,468.4 | 76,468.4 | - | 100.0 |
| 4. | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 28,090.2 | 26,511.6 | 1,578.6 | 94.4 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 1,868,953.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 61,403.2 мянган төгрөг нийт 1,930,356.0 мянган төгрөг орж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл 20 хувь буюу 54,596.3 мянган төгрөг, нийгмийн даатгалд 6,801.3 мянган төгрөг, шатахуун 12,567.5 мянган төгрөг, томилт 12,567.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 1,838,026.9 мянган төгрөгийг тус тус зарцуулж улсын төсөвт 5,378.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа бичиг хэрэг, тээвэр шатахуун, эм бэлдмэл, нормын хувцас багаж техник хэрэгсэл, урсгал засвар нийт 17,358.3 мянган төгрөгөөр төсөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 65,313.7 мянган төгрөг зарцуулсан, урсгал засвар үйлчилгээний зардал батлагдсан төлөвлөгөөнөөс 32,432.1 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн анхан шатны баримттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ын аудитор Б.Дашням гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 24 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 493,183.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,397.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн 2023 оны 5,990,778.1 мянган төгрөгийн нийт зардлын дүнгээс 1.5 хувиар тооцож 67,396.2 мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын цалин хөлс болон нэмэгдэл цалинг 295,371.5 мянган төгрөг орон тоо дутуу ажилласнаас хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 159 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 159 мэдээллээс 159 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш өссөн дүнтэй 1,223,512.7 мянган төгрөгийн гүйлгээг оруулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв орхигдуулсан зүйлгүй оруулдаг байх зөвлөмж хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Мөнгөн хөрөнгийн түүврээр үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 426,744.0 мянган төгрөгийн цахим баримт илүү шивэгдсэн зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “ холбогдох олон улсын стандарт , эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй”; 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 56.8 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илрүүлж, алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж 2 зөвлөмжийн хэрэгжилт дутуу хэрэгжсэн байх тул гүйцэтгэлээр давтан шалгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 9,052.6 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрч 3 албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн ажиллаж биелэлт 100 хувьтай, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчил давтан гарсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт
/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|-----------------|------------------------|----------------|----------|----------------|------------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Албан шаардлага | 3 | 4,472.5 | 3 | 4,472.5 | 100 |
| Акт | 3 | 2,881.3 | 3 | 2,881.3 | 100 |
| Нийт дүн | 6 | 7,353.8 | 3 | 7,353.8 | 100 |

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Төсөв, санхүүжилтийг үндэслэлтэй баталдаг байх,
2. Худалдан авалтын төсвийг үндэслэлтэй баталсан эсэх, худалдан авалтын хэтрэлтийг анхаарч шалгах.
3. Цахим баримтын хяналтыг хэрэгжүүлэн ажилладаг байх, төрийн чиг үүргийг оновчтой удирдлагаар ханган хэрэгжүүлэн ажиллах талаар анхаарал хандуулах талаар үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 431,689.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 426,744.7 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 3 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлуулаагүй 4,278.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байхаар төлөвлөж, зарцуулах", Санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг үндэслэлтэй үнэн зөв батлуулдаг байх, төлөвлөгөөний дагуу худалдан авалтыг хийх.

2. Өглөгийн талаар холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн 339.7 мянган төгрөгийн өглөгтэй гарсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах, аудитын батламж мэдэгдлийн оршин байх "Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж байгууллагад бодитой оршин байх", эрх ба үүрэг "Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өглөг уг аж ахуй нэгж байгууллагад хамааралтай, эзэмших, бүртгэх эрхтэй, өр төлбөрийг төлөх үүрэгтэй байх" гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өглөг авлага үүсгэхгүй ажиллах.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Бодогдсон цалин 2,255.9 мянган төгрөгийн цалинтай ажилчны нийгмийн даатгалын тайланг хүүхдээ асарч байгаа чөлөөтэй гэж буруу тайлагнаж 327.1 мянган төгрөгийн зөрүү үүссэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх;" , Санхүүгийн тайлангийн "үнэлгээ ба хувиарлалт" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйлгээг үнэн зөв бүртгэж тайлагнах, тооцооллын алдаа гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|----------------|---------------|-----|-----------------|-----|----------|----------------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Төлөвлөгөөнд батлуулаагүй 4,278.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан | 1 | 4,278.0 | | | | | 1 | 4,278.0 | | | | |
| Тайлант онд 339.8 мянган төгрөгийн өглөг үүсгэж ажилласан. | 1 | 339.8 | | | | | 1 | 339.8 | | | | |
| Нэг ажилчны нийгмийн даатгалыг буруу ангиллаар тайлагнаж 327.1 мянган төгрөгийн зөрүү тооцоолол гаргасан. | 1 | 327.1 | | | | | 1 | 327.1 | | | | |
| Дүн | 3 | 4,944.9 | | | | | 3 | 4,944.9 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|-------------|------------------|---------------|-----|-----------------|------------------|----------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш өссөн дүнтэй гүйлгээг дутуу оруулсан байна. | 1 | | | | | | 1 | |
| Дүн | 1 | | | | | | 1 | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цахим баримт илүү шивэгдсэн | 1 | 426,744.0 | | | 1 | 426,744.0 | | |
| Дүн | 1 | 426,744.0 | | | 1 | 426,744.0 | | |
| Нийт дүн | 2 | 426,744.0 | | | 1 | 426,744.0 | 1 | |



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 08-14510516-ТБА-2024/10/НА-СТД-ТУС Зуунмод

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 426,744,000 /дөрвөн зуун хорин зургаан сая долоон зуун дөчин дөрвөн мянган/ төгрөгийн цахим баримт илүү шивэгдсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “ холбогдох олон улсын стандарт , эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим баримт илүү шивэгдсэн, гүйлгээ хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт³ ирүүлэх;

³Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019049335

2.Цаашид алдаа⁴, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Мал эмнэлгийн газрын дарга Б.Болдбаатар, нягтлан бодогч Ц.Отгончимэг нарт даалгав.



АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/С.ОЮУНГЭРЭЛ/

⁴Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582